



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2025 оны 10 сарын 02 өдөр

Дугаар А/622

Булган сум

“Гамшгаас хамгаалах иж бүрэн сургууль”  
зохион байгуулахад хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.2, 32.1.3 дахь заалт, “Булган аймгийн 2025 оны төсөв батлах тухай” Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны IV/26 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Булган аймагт 2025 оны 09 дүгээр сарын 24-26-ны өдрүүдэд зохион байгуулагдах “Гамшгаас хамгаалах иж бүрэн сургууль”-д иргэдийг нүүлгэн шилжүүлэх, тээвэрлэн хүргэх үйл ажиллагааг зохион байгуулахад Булган сумын онцгой комисст 6,000,000 (зургаан сая) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2.Гамшгаас хамгаалах иж бүрэн сургуулийн иргэдийг нүүлгэн шилжүүлэх, тээвэрлэн хүргэхдээ иргэдийн аюулгүй байдлыг ханган, дэг журам, сахилга хариуцлагатай зохион байгуулж ажиллахыг Булган сумын Засаг дарга (Д.Бямбажаргал)-д даалгасугай.

3.Шаардагдах зардал 6,000,000 (зургаан сая) төгрөгийг Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг нягтлан бодогч (Э.Эрдэнэжаргал)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Д.ЛҮРЭВ-ОЧИР



8325010864